



**ҮЙЛДВЭР,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ**

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 2012/09

**Улаанбаатар хот
2012 он**



ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Аж үйлдвэрийн салбар	2
2. Мал аж ахуйн салбар	8
3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	10
4. Газар тариалангийн салбар	11
5. Цаг агаарын ерөнхий төлөв	13

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.



1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны эхний 9 сард 1565.6 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 93.6 тэрбум төг буюу 6.4 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2012 оны эхний 9 сард 4072.4 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 427.5 тэрбум төг буюу 11.7 хувиар өссөн.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний 9 сард оны үнээр 4298.1 тэрбум төг болж, 2784.4 тэрбум төг буюу 64.8 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

**Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, дэд салбараар,
2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төг**

<i>Аж үйлдвэрийн салбар</i>	<i>2011^{I-X}</i>	<i>2012^{I-X}</i>	<i>2011^{I-X}</i>	<i>2012^{I-X}</i>	<i>$\frac{2012^{I-X}}{2011^{I-X}}$ (%)</i>
Аж үйлдвэрлийн нийт бүтээгдэхүүн, 2005 оны зэрэгцүүлэх үнээр	191645.6	185008.7	1471983.7	1565568.0	106.4
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	56649.4	56948.2	444603.1	478473.7	107.6
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	26922.8	29329.0	217546.3	247433.4	113.7
Тамхи үйлдвэрлэл	2600.1	2162.1	17132.3	15902.6	92.8
Нэхмэлийн үйлдвэрлэл	7889.7	7670.8	81254.0	60364.1	74.3
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	686.7	321.1	10179.7	3703.7	36.4
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	732.0	1374.9	2142.9	6103.4	284.8
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	434.7	292.8	1881.0	1940.0	103.1
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	297.5	290.8	2058.8	3196.0	155.2
Тавилга үйлдвэрлэл, бусад	82.3	86.6	724.0	2436.9	336.6



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, дэд салбараар, оны үнээр, сая төг

<i>Аж үйлдвэрийн салбар</i>	<i>2011^{IX}</i>	<i>2012^{IX}</i>	<i>2011^{I-IX}</i>	<i>2012^{I-IX}</i>	$\frac{2012^{I-IX}}{2011^{I-IX}}$ <i>(%)</i>
Аж үйлдвэр, бүгд	575026.6	511332.6	3988266.8	4298062.5	107.8
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	199380.6	178928.2	1006538.2	1394134.7	138.5
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	58496.2	54439.4	458117.3	540268.7	117.9
Тамхи үйлдвэрлэл	3388.5	6703.1	31949.3	34906.2	109.3
Нэхмэлийн үйлдвэрлэл	24459.9	17961.4	147313.2	129102.6	87.6
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	698.1	2814.2	6947.6	8454.9	121.7
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	151.2	1845.5	1720.7	5607.8	325.9
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	1064.1	1465.1	6565.5	9491.5	144.6
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1095.1	1282.0	8370.5	11718.9	140.0
Тавилга үйлдвэрлэл, боловс/ үйлдвэрийн бусад	110.2	112.6	1063.3	1450.7	136.4

Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

<i>Бүтээгдэхүүн</i>	<i>хэм. нэгж</i>	<i>2011^{IX}</i>	<i>2012^{IX}</i>	<i>2011^{I-IX}</i>	<i>2012^{I-IX}</i>	$\frac{2012^{I-IX}}{2011^{I-IX}}$ <i>%</i>
Хивс	мян.м2	71.9	90.8	600.6	656.3	109.3
Сүлжмэл эдлэл	мян.ш	74.0	71.8	538.5	593.4	110.2
Самнасан ноолуур	тн	46.0	45.2	815.3	301.6	37.0
Эсгий	мян.м	31.4	24.2	163.4	169.2	103.5
Тэмээний ноосон	мян.м	6.1	-	18.5	2.6	14.1

хөнжил

Эсгий гутал	мян.хос	4.0	4.1	26.4	22.6	85.6
Нэхий дээл	ш	2186	76	12174	3184	26.2
Савхин гутал, ботинк	мян.хос	0.6	1.1	4.9	8.9	182.4
Барилгын модон хаалга, цонх	м2	3777.1	582.9	8444.8	4790.8	56.7
Барилгын шалны банз	м3	-	20.0	148.0	957.8	647.2
Зүсмэл материал	м3	888.7	2323.1	8164.0	9936.2	121.7
Дэвтэр	мян.ш	1319.6	839.1	7400.8	9038.8	122.1
Ариун цэврийн цаас	мян.ш	202.3	511.9	2047.9	3754.7	183.3
Бичгийн цаас	тн	9.7	12.5	139.3	114.7	82.3
Сонин	сая.х.д.х	3.8	10.9	29.5	48.2	163.6
Ном	сая.х.д.х	4.0	4.5	32.1	43.8	136.5
Шахмал түлш	тн	631.5	1559.5	3055.9	5689.0	186.2
Гоо сайхны тос	мян.ш	70.3	57.8	462.8	537.2	116.1
Вакуум цонх, хаалга	м2	1281.4	2798.1	7317.3	9142.3	124.9
Цемент	мян.тн	50.8	18.2	326.1	286.8	87.9
Бетон зуурмаг	м3	12503.3	7383.5	46547.8	49846.6	107.1


Хүнсний салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 ^{IX}	2012 ^{IX}	2011 ^{I-IX}	2012 ^{I-IX}	$\frac{2012^{I-IX}}{2011^{I-IX}} \%$
Үхрийн мах	тн	462.3	146.5	655.4	621.3	94.8
Хонины мах	тн	179.6	3.5	413.5	419.5	101.5
Адууны мах	тн	102.1	0.2	159.4	17.0	10.7
Ямааны мах	тн	15.0	-	74.7	300.0	401.6




Гахайн мах	тн	1.5	1.7	14.6	15.5	106.2
Өлөн гэдэс	мян.гогцоо	191.1	114.6	925.1	777.1	84.0
Хиамны зүйл	тн	193.4	188.5	1541.2	1605.3	104.2
Шингэн сүү	мян.л	1568.4	2312.8	15572.9	18476.9	118.6
Тараг	мян.л	776.9	547.7	6916.8	5856.9	84.7
Цөцгий, цөцгийн тос	тн	90.5	79.3	665.7	1171.5	176.0
Аарц, бяслаг	тн	6.7	26.2	47.5	232.7	489.9
Дээд гурил	тн	1268.5	3441.4	16744.8	19934.4	119.0
Нэгдүгээр гурил	тн	5853.4	5033.5	47839.2	45002.0	94.1
Хоёрдугаар гурил	тн	539.2	567.2	7789.2	10572.6	135.7
Малын тэжээл	тн	2714.9	3344.0	23314.5	24703.6	106.0
Нарийн боов	тн	1164.1	1195.2	9332.2	9919.9	106.3
Бялуу	тн	26.7	85.0	378.6	648.1	171.2
Чихэр	тн	5.4	7.0	60.4	71.7	118.7
Талх	тн	2254.2	2316.3	16458.8	18440.4	112.0
Гоймон	тн	229.2	445.0	1587.8	2263.2	142.5
Спирт	мян.л	228.6	93.1	2479.1	2387.2	96.3
Архи	мян.л	2226.8	2807.2	19286.7	20917.1	108.5
Дарс	мян.л	3.3	6.3	86.1	57.2	66.4
Шар айраг	мян.л	5305.3	5049.3	41357.7	50029.9	121.0
Цэвэр ус	мян.л	2959.1	3332.3	23528.9	26875.3	114.2
Амтат ус, ундаа	мян.л	7286.0	6958.2	57944.9	59723.4	103.1
Жүүс	мян.л	4671.6	6016.0	38912.9	48825.8	125.5


Мах үйлдвэрлэл, тн




Сүү, тараг үйлдвэрлэл, мян.л



Гурил үйлдвэрлэл, тн



Цэвэр ус, жүүс үйлдвэрлэл, мян.л



Экспортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 ^{I-IX}	2012 ^{I-IX}	$\frac{2012^{I-IX}}{2011^{I-IX}} \%$
Үхрийн хөлдүү мах	т	3390.4	18.9	0.6
Адууны мах	т	882.0	350.1	39.7
Малын дайвар бүтээгдэхүүн	т	264.3	820.2	310.4
Шеврет	сая дм ²	260.0	124.2	47.8
Шевро	сая дм ²	112.0	44.2	39.5
Адууны шир	мян.ш	141.1	97.5	69.1
Хонины самнаагүй ноос	т	6342.0	2655.3	41.9
Бохир ноолуур	т	2625.3	3486.1	132.8
Самнасан ноолуур	т	389.0	384.4	98.8
Свитер, пуловер, джемпер, жилет болон сүлжмэл гадуур цамц	мян.ш	84.9	108.8	128.2

Импортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 ^{I-IX}	2012 ^{I-IX}	$\frac{2012^{I-IX}}{2011^{I-IX}} \%$
Өндөг	мян.ш	48166.3	63841.1	132.5
Төмс	т	5702.3	3132.6	54.9
Сонгино, сармис	т	11485.2	6340.7	55.2
Алим, лийр	т	5586.6	3047.7	54.6
Ногоон цай	т	1778.2	1424.6	80.1
Цагаан будаа	т	7528.4	26513.0	352.2
Шар будаа	т	825.2	987.0	119.6
Улаанбуудай	мян.т	2.2	4.1	184.5
Гурил	мян.т	47.6	45.1	94.7
Ургамлын тос	т	3677.5	5032.3	136.8
Элсэн чихэр	т	28287.0	33298.9	117.7
Хатуу чихэр	т	4049.1	4232.5	104.5
Согтууруулах биш ундаа	мян.л	14558.3	16377.5	112.5
Согтууруулах ундаа	мян.л	17437.9	23390.2	134.1
Үүнээс: Шар айраг	мян.л	15761.5	21756.3	138.0
Янжуур	сая.ш	1342.5	1649.1	122.8
Азотын бордоо	т	28012.3	54288.6	193.8

2.МАЛ АЖ АХУЙН САЛБАР

Улсын хэмжээнд 2011 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 15.7 сая хээлтэгч малын 13.7 сая хээлтэгч буюу 87.0 хувь нь 2012 оны эхний 9 сард төллөсөн байна. Эм хонины 91.1 хувь, эм ямааны 87.3 хувь, үнээний 71.7 хувь, гүүний 68.7 хувь, ингэний 47.4 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 98.3 хувь буюу 13430.9 мян.толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 780.8 мянга буюу 6.2 хувиар их байна.

Унага бойжилт 97.4 хувь, тугал 98.0 хувь, ботго 98.0 хувь, хурга 98.6 хувь, ишиг бойжилт 98.1 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.3-1.4 пунктээр өсчээ.

Улсын хэмжээгээр 2012 оны эхний 9 сард 297.1 мянган толгой мал зүй бусаар хорогдож, өмнөх оны мөн үеийнхээс 228.1 мянган толгой буюу 43.4 хувиар буурав. Зүй бусаар хорогдсон малыг төрлөөр авч үзвэл адуу 15.4 мянга, үхэр 27.3 мянга, тэмээ 743, хонь 122.0 мянга, ямаа 131.6 мянга байна. Нийт хорогдлын 41.1 хувийг хонь, 44.3 хувийг ямаа эзэлж байна.

Улсын хэмжээнд 2012 оны эхний 9 сард 20.6 мянган толгой мал өвчнөөр хорогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 1.1 мянга буюу 5.1 хувиар буурчээ.

Мал төллөлт

(жил бүрийн эхний 9 сарын байдлаар)

Эх малын төрөл	Төллөсөн хээлтэгч, мян.толгой			Төллөлтийн хувь		
	2010 ^{I-IX}	2011 ^{I-IX}	2012 ^{I-IX}	2010 ^{I-IX}	2011 ^{I-IX}	2012 ^{I-IX}
Бүгд	10461.1	12992.4	13 658.9	55.0	83.6	87.0
Гүү	280.5	392.8	440.9	43.2	66.2	68.7
Үнээ	510.3	604.8	692.1	49.8	67.1	71.7
Ингэ	36.8	40.3	45.6	41.1	44.4	47.4
Эм хонь	5481.3	6181.7	6 481.2	63.2	87.1	91.1
Эм ямаа	4152.2	5772.8	5 999.1	48.5	84.3	87.3


Төл бойжилт

(жил бүрийн эхний 9 сарын байдлаар)

Төлийн төрөл	Бойжуулсан төл, мян.толгой			Бойжилтын хувь		
	2010 ^{I-IX}	2011 ^{I-IX}	2012 ^{I-IX}	2010 ^{I-IX}	2011 ^{I-IX}	2012 ^{I-IX}
Бүгд	7476.6	12650.1	13 430.9	71.3	97.1	98.3
Унага	236.9	379.9	428.3	84.4	96.7	97.4
Тугал	446.2	590.8	677.3	87.4	97.7	98.0
Ботго	33.9	39.1	44.5	92.0	97.2	98.0
Хурга	3972.1	6020.2	6394.8	72.3	97.2	98.6
Ишиг	2787.6	5620.1	5886.0	67.0	97.0	98.1

Зүй бусаар хорогдсон том мал
(жил бүрийн эхний 9 сарын байдлаар)

Малын төрөл	Хорогдсон том мал, мян.тол			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2010 ^{I-IX}	2011 ^{I-IX}	2012 ^{I-IX}	2010 ^{I-IX}	2011 ^{I-IX}	2012 ^{I-IX}
Бүгд	9822.5	525.2	297.1	22.3	1.6	0.8
Адуу	342.1	21.6	15.4	15.4	1.1	0.7
Үхэр	557.5	42.5	27.3	21.4	2.0	1.2
Тэмээ	13.1	1.3	0.7	4.7	0.5	0.3
Хонь	4089.6	220.4	122.0	21.2	1.5	0.8
Ямаа	4820.1	239.3	131.6	24.5	1.7	0.8




ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2012 оны 9 дүгээр сард үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Хөвсгөл, Ховд, Сүхбаатар, Завхан, Увс, Булган, Өвөрхангай, Говьсүмбэр, Дундговь аймагт хамгийн бага буюу 20.0-25.0 мян.төг, Орхон, Төв, Архангай аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 35.0-40.0 мян.төг, адууны ширнийх Увс, Говь-Алтай, Завхан, Ховд, Хөвсгөл, Өмнөговь аймагт хамгийн бага буюу 23.0-25.0 мян.төг, Баян-Өлгий, Орхон, Төв, Хэнтий, Архангай аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 33.5-38.0 мян.төг, ямааны 1 кг цагаан ноолуурын үнэ Баян-Өлгий, Завхан, Дорноговь, Өмнөговь, Увс, Дундговь, Ховд аймагт хамгийн бага буюу 35.0-42.0 мян.төг, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Говь-Алтай аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 45.0-46.0 мян.төг байна.


Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Дундговь, Ховд, Завхан, Архангай, Баянхонгор аймагт өмнөх сарынхаас 1.5-5.0 мян.төг буюу 6.4-20.0 хувиар өсч, Төв, Дархан-Уул, Өвөрхангай, Хөвсгөл, Булган аймагт 1.5-7.0 мян.төг буюу 4.1-21.9 хувиар буурч, Орхон, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар аймаг, Улаанбаатар хотод өмнөх сарын түвшинд байв.

Адууны 1 ширхэг ширний дундаж үнэ Ховд, Сэлэнгэ, Төв, Сүхбаатар аймагт өмнөх сарын түвшинд, бусад аймаг, Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 1.0-6.0 мян.төг буюу 3.8-20.0 хувиар өсөв.

Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 9 дүгээр сард, мян.төг



Адууны 1 ширхэг ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 9 дүгээр сард, мян.төг



Ямааны 1 кг цагаан ноолуурын дундаж үнэ Говь-Алтай, Сүхбаатар аймагт өмнөх сарынхаас 0.5-1.5 мян.төг буюу 1.1-3.7 хувиар өсч, Орхон, Баянхонгор, Хөвсгөл, Увс, Дорноговь, Дундговь, Баян-Өлгий аймаг, Улаанбаатар хотод 2.0-7.0 мян.төг буюу 4.3-16.7 хувиар буурч, Завхан, Архангай, Өвөрхангай, Дархан-Уул аймагт өмнөх сарын түвшинд байв.

Ямааны 1 кг цагаан ноолуурын зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 9 дүгээр сард, мян.төг



3. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАР

Улсын хэмжээгээр 2012 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар 226.3 мян.т үр тариа, 219.6 мян.т төмс, 77.4 мян.т хүнсний ногоо хурааж, 1030.2 мян.т хадлан, 25.2 мян.т гар тэжээл, 504.5 т дарш бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс төмс 36.7 мян.т буюу 20.1 хувь, хадлан 20.8 мян.т буюу 2.1 хувь, дарш 143.4 т буюу 39.7 хувиар өсч, үр тариа 133.2 мян.т буюу 37.1 хувь, хүнсний ногоо 11.5 мян.т буюу 12.9 хувь, гар тэжээл 2.7 мян.т буюу 9.7 хувиар буурсан байна.

Га тутмаас 15.8 цн үр тариа, 145.1 цн төмс хураасан нь өмнөх оны мөн үеийнхээс үр тариа 0.8 цн буюу 5.3 хувь, төмс 15.4 цн буюу 11.9 хувиар илүү байна. Үр тарианы га-гийн ургац Сэлэнгэ, Булган, Баянхонгор, Төв, Орхон, Баян-Өлгий аймагт улсын дунджаас 0.1-7.4 центнерээр өндөр харин бусад аймагт 0.9-6.7 центнерээр доогуур байна.


Бүсээр авч үзэхэд хураасан үр тарианы 74.7 хувь нь Төв, 17.8 хувь нь Хангай, 3.8 хувь нь Зүүн, 3.7 хувь нь Баруун бүсэд ногдож байна. Хураасан үр тарианы 57.6 хувь нь Сэлэнгэ, 12.7 хувь нь Төв, 11.4 хувь нь Булган, 5.3 хувь нь Хөвсгөл аймагт ногдож байна.

Төмсний га-гийн ургац Сэлэнгэ, Төв аймагт улсын дунджаас 19.5-40.6 центнерээр өндөр харин бусад аймагт 7.9-122.8 центнерээр доогуур байна. Төмсний 40.4 хувь нь Төв, 25.9 хувь нь Сэлэнгэ, 6.1 хувь нь Дархан-Уул, 5.8 хувь нь Ховд, 3.4 хувь нь Булган аймагт ногдож байна.


Хураасан нийт хүнсний ногооны 29.7 мян.т буюу 38.3 хувь нь Сэлэнгэ, 8.6 мян.т буюу 11.1 хувь нь Ховд, 8.3 мян.т буюу 10.7 хувь нь Төв, 7.1 мян.т буюу 9.2 хувь нь Дархан-Уул, үлдсэн 23.8 мян.т буюу 30.7 хувь нь нийслэл, бусад аймагт ногдож байна.

Бэлтгэсэн нийт хадлангийн 165.2 мян.т буюу 16.4 хувь нь Сэлэнгэ, 147.9 мян.т буюу 14.6 хувь нь Хөвсгөл, 122.7 мян.т буюу 12.1 хувь нь Хэнтий, 92.6 мян.т буюу 9.2 хувь нь Булган, 74.9 мян.т буюу 7.4 хувь нь Архангай, 74.5 мян.т буюу 7.3 хувь нь Төв, 59.5 мян.т буюу 5.9 хувь нь Ховд, 58.2 мян.т буюу 5.8 хувь нь Баян-Өлгий аймагт, үлдсэн 214.7 мян.т буюу 21.3 хувь нь нийслэл, бусад аймагт ногдож байна.

Хураасан үр тариа, мян.т



Хураасан төмс, хүнсний ногоо, мян.т



Өдөйр ашиглангийн өсөлт, хэвгэлтэй 10 ачаагаар нэгдүг 1-рөө ачаагаар


га

Аймгийн нэр	2011.X.1	2012.X.1	$\frac{2012.X.1}{2011.X.1} \times 100\%$
Завхан	3 000.0	3 000.0	100.0
Увс	-	3 500.0	-
Архангай	3 800.0	3 800.0	100.0
Булган	30 000.0	32 400.0	108.0
Орхон	4 320.0	4 550.0	105.3
Өвөрхангай	3 580.0	3 050.0	85.2
Хөвсгөл	15 050.0	14 000.0	93.0
Дархан-Уул	10 738.0	12 540.0	116.8
Сэлэнгэ	141 147.0	141 340.0	100.1
Төв	65 000.0	51 904.0	79.9
Дорнод	13 840.0	18 300.0	132.2
Хэнтий	7 300.0	11 430.0	156.6
Дүн	297 775.0	299 814.0	100.7


ЦАГ АГААРЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ **
Арваннэгдүгээр сар

Агаарын температурын сарын дундаж нь Баян-Өлгий, Ховдын ихэнх нутаг, Увсын зүүн, Говь-Алтай, Өмнөговийн баруун, Баянхонгорын өмнөд хэсгээр олон жилийн дунджаас 1.0 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байна (**3 дугаар зураг**).

Энэ сард Баян-Өлгий, Архангай, Дорнодын хойд, Увсын баруун өмнөд, Хөвсгөлийн зүүн өмнөд, Булганы баруун, Хэнтийн зүүн хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Баян-Өлгийн зүүн өмнөд, Ховд, Баянхонгор, Өмнөговь, Дорноговийн өмнөд хэсэг, Завханы баруун өмнөд, Говь-Алтайн баруун, Хөвсгөлийн баруун хойд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим цас орно (**4 дүгээр зураг**).



3 дугаар зураг. 11 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан мэдээ
Air temperature forecast, November



4 дүгээр зураг. 11 дүгээр сард орох хур тунадасны урьдчилсан мэдээ
Precipitation forecast, November

** Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус, цаг уурын хүрээлэн